

Хорон муу явдал ба Аврагчийн хүч

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Энэ дэлхий дээрх хорон муу явдлын зарим жишээг болон энэ нь бидэнд хэрхэн нөлөөлөх талаар бодож үз.

- Хэрэв та энэ дэлхийн хорон муу явдлыг төлөөлөх ямар нэг зүйлийн талаар бодвол энэ нь юу байх байсан бэ? Яагаад?
- Хэрэв та Аврагчийг төлөөлөн мөн Тэрээр бидэнд хэрхэн тэрхүү хорон мууг ялан дийлэхэд туслах хүндлэлийн бэлгэдэл эсвэл нэр цолны талаар бодвол энэ нь юу байх байсан бэ? Яагаад?

Тэмдэглэлийнхээ нэг хуудсыг дундуур нь хуваа. Илчлэл 17:3–7-г уншаад, Иоханы эдгээр шүлэгт ашигласан бэлгэдлүүдийг төсөөл. Тэмдэглэлийнхээ хуваасан хуудасны нэг талд хорон муу явдлыг дүрсэлсэн түлхүүр үг, хэллэгийг жагсаан бич. Нөгөө талд нь Есүс Христийг болон зөв шударга байдлыг илэрхийлсэн бэлгэдлүүдийг бич. Дараах үгс тус болж болох юм. Үүнд:

Завхайрал (Илчлэл 17:4): бэлгийн харилцааны ёс зүйгүй үйлдлүүд. Энэ нь мөн “урвалтын бэлгэдэл” (Судруудын удирдамж, “Завхайрал,” scriptures.ChurchofJesusChrist.org) байж болно.

Вавилон (Илчлэл 17:5): хорон муу явдлаараа алдартай хот, хорон муу явдал, дэлхийн хэрэг явдлын бэлгэдэл болгож ашиглагддаг

Янхан (Илчлэл 17:5): мөнгө эсвэл бараа таваарын төлөө бэлгийн харилцааны ёс зүйгүй үйлдэл үйлддэг хүн

Гайхах (Илчлэл 17:6): гайхширал, эргэлзээ (6-р шүлэг , зүүлт тайлбар 8-г үзнэ үү)

- Та уншсан бэлгэдлүүдийнхээ талаар юу олж мэдсэн бэ?
- 14-р шүлэг дэх Есүс Христийн нэр цол Түүний талаар ойлгоход тань хэрхэн тусалж байна вэ?

- Та Хурга буюу Есүс Христ бүх хорон муу явдлыг ямар арга замаар даван туулсан талаар юу мэдэх вэ? (Судруудын удирдамж, “Бурханы Хурга,” scriptures.ChurchofJesusChrist.org-ыг үзнэ үү.) Энэ нь таны хувьд ямар утгатай вэ?

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ